

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 29

Дугаар 302

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ШАГНАЛЫН ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1."Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 40 дүгээр зарлигаар батлагдсан " Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм" болон "Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2005 оны 54 дүгээр зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР